



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А193

Улаанбаатар хот

Энхийг сахиулагчдын өдрийг
тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 2.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 140 дугаар тогтоол, 2019 оны 200 дугаар тогтоол, Батлан хамгаалах сайдын Нийслэлийн засаг даргатай байгуулсан 2024 оны гэрээний 1,7 1,8 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас баталсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас зохион байгуулагдаж байгаа “Бидний бахархал” төслийн хүрээнд дүүргийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас Нэгдсэн үндэсний байгууллагын мандаттай энхийг дэмжих ажиллагаа болон Олон Улсын хамтарсан энхийг сахиулах ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүнийг дүүргийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, ахлах ангийн сурагчдын дунд хийн буудлагын тэмцээнийг Засаг даргын тамгын газрын Цэргийн штаб, дүүргийн Биеийн тамир, спортын хороотой хамтран 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс 27-ны өдрүүдэд зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

2. Дүүргийн Ерөнхий боловсролын “Хангай” сургуулийн сурагчдыг “Эх оронч суралцагч” сэдэвт арга хэмжээнд батлагдсан хөтөлбөр удирдамжийн дагуу зохион байгуулж оролцуулахыг “Хангай” сургууль (Э.Соёмбобат)-д даалгасугай.

3. Энхийг сахиулагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаанд оролцох албан тушаалтны нэрийн жагсаалтыг нэгдүгээр, Энхийг сахиулагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаанд шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Энхийг сахиулагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаанд шаардагдах 1.015,200 (нэг сая, арван таван мянга, хоёр зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д үйл ажиллагааг зохион байгуулж дууссанаас хойш 5 хоногийн дотор дүнг танилцуулж, зарцуулсан санхүүгийн тайланг ирүүлэхийг Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-өлзий)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL/2024 он ажил/захирамж

1123200253